

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ**

2017 оны ... сарын  
... -ны өдөр

Дугаар .....

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журмыг хавсралтаар баталсугай баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогчдод үүрэг болгосугай.

3. Энэхүү журмыг 2018 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс туршилтаар хэрэгжүүлж, удирдамж батлан хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж, холбогдох зарим байгууллагатай гэрээ, төлөвлөгөө хамтран байгуулж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн газар (С.Тунгалагтамир), Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар(Л.Чой-Иш)нарт даалгасугай.

4. Хөтөч нохойг сургах, түүнийг хэрэглэх журмын хэрэгжилтийн байдалд 2 жил тутам хяналт шинжилгээ, үнэлгээ хийж Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх дэд зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Ц.Мөнхзул)-т үүрэг болгосугай.

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН  
ҮЙЛДВЭРИЙН САЙД

Н.НОМТОЙБАЯР

П.СЭРГЭЛЭН

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан 2017 оны ... дугаар сарын ... -ны өдрийн ..... дугаар тушаалын хавсралт

## **ХӨТӨЧ НОХОЙГ СУРГАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасан иргэнд хөтөч эсвэл туслагч нохойны тусламжтайгаар олон нийтийн газарт нэвтрэх, тус хуулийн 4.1.2, 4.1.11 зэрэг холбогдох заалтыг хэрэгжүүлж баталгаажуулахад чиглэгдэнэ.

1.2. Хөтөч нохой гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 4.1.12-д заасан нохойг хэлнэ.

1.3. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа гадаадын болон хамтарсан хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагаэнэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.

1.4. Хөтөчнохой эзэмшиж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь гудамж талбай, явган хүний зам, гарц, олон нийтийн барилга байгууламж, зочид буудал болон бусад нийтэд үйлчилгээ үзүүлдэг газар эрх тэгш үйлчлүүлэх эрхтэй.

1.5. Хөтөч нохой нь нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчино.

1.6. Хөтөч нохойтой хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг олон нийтэд зориулсан барилга байгууламжид нэвтрэн орох, үйлчилгээ авахад нь саад учруулах, хориглох зэргээр ялгаварлан гадуурхаж үл болно.

1.7. Хөтөч нохой эзэмшигч эсвэл сургалтад хамрагдаж буй хөтөч болон туслагч нохойг хэрэглэж буй аливаа этгээд нь төрийн ..... орон нутгийн төлбөр хураамжаас тусгайлан зааснаас бусад тохиолдолд чөлөөлөгдөнө.

### **Хоёр. Хөтөч нохойг сургах сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох**

2.1. Хөтөч нохой нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг бие даан амьдрахад нь дэмжлэг үзүүлэх түвшинд энгийн болон ур чадвар шаардсан үйлдэл, саад бэрхшээлийг даван туулахуйц хэмжээнд бэлтгэгдсэн байна.

2.2. Хөтөч нохойг 2.1-д заасан түвшинд сургаж бэлтгэх байгууллага нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас нохой сургах сургалт зохион байгуулах гэрчилгээ авсан байна.

2.3. Цагдаагийн ерөнхий газрын Нохой сургалтын төвд энэ журмын 2.2 дахь заалт хамаарахгүй.

2.4. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас сургалтын гэрчилгээ авсан байгууллагуудыг Цагдаагийн ерөнхий газар бүртгэж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана.

2.5. Хөтөч нохойн сургалт зохион байгуулах төрийн болон төрийн бус байгууллага нь дараах шаардлагыг хангасан байна.

2.5.1. Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, дадлага олгох анги танхимтай байх;  
2.5.2. Нохой сургалтын чиглэлээр мэргэшсэн 3-аас доошгүй сургагч багштай байх;  
2.5.3. Сургалт зохион байгуулах техник хэрэгсэл, үзүүлэн таниулах материал, дадлагын газартай байх;

2.6. Хөтөч нохойн сургалт зохион байгуулах гэрчилгээ авах байгууллага нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт дараахь материалыг бүрдүүлж ирүүлнэ.

2.6.1. Гэрчилгээ авахыг хүссэн албан бичиг;

2.6.2. Энэ журмын 2.5.1, 2.5.2, 2.5.3-д заасан шаардлагыг хангасан талаар танилцуулга;

2.6.3. Хөтөч нохой сургалтын хөтөлбөр;

2.6.4. Сургалт явуулах багш, сургагчдын анкет, тэдний нохой сургалтын чиглэлээр мэргэшсэн гэрчилгээ, сертификат;

2.6.5. Тухайн байгууллагын гэрчилгээний хуулбар(нотариатаар батлуулсан байх);

2.7. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь тухайн байгууллагын ирүүлсэн материалыг судалж, холбогдох дүгнэлт саналболовсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх салбар дундын дэд зөвлөлийн хуралд танилцуулна.

2.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх дэд зөвлөлийн хуралд танилцуулсны үндсэн дээр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас Хөтөч нохойн сургалт зохион байгуулах гэрчилгээг 3 хүртэл жилийн хугацаатай олгоно.

2.9. Хөтөч нохойн сургалт зохион байгуулах гэрчилгээний хугацаа дууссан тохиолдолд тухайн байгууллага хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө гэрчилгээг сунгуулах хүсэлт, үйл ажиллагааны тайлангаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт ирүүлнэ. ХХҮЕГ тухайн байгууллагын хүсэлт, үйл ажиллагааны үр дүнг судлан, дүгнэлт саналаа Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаарх салбар дундын дэд зөвлөлийн хуралд танилцуулж, гэрчилгээг энэ журмын 2.8-д заасан хугацаагаар сунгана.

2.10. Хөтөч нохойн сургалт зохион байгуулах гэрчилгээний загварыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар батална. Гэрчилгээнд олгосон огноо, хүчинтэй байх хугацаа, Хөтөч нохойн сургалтын төрөл, сургалт зохион байгуулах байгууллагын шаардлагатай мэдээлэл зэргийг оруулна.

2.11. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь хөтөч нохойтой хэрхэн харилцах, аливаа үйлдлийг хамтдаа хийх, нийгмийн харилцаанд хэрхэн оролцох ойлголтыг авах үүднээс хамтдаа 21-30 хоногийн сургалтад хамрагдана.

### **Гурав. Хөтөч нохойг хэрэглэх, зохион байгуулалт**

3.1. Хөтөч нохойн сургалт зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж буй байгууллагын удирдлага, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын дарга, захирал, удирдлага шууд хариуцна.

3.2. Хөтөч нохойтой болох хүсэлтэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн өөрийн оршин сууж буй газрын сум, хороонд хүсэлт гаргана. Хүсэлтийг нийгмийн ажилтан(цаашид нийгмийн ажилтан гэх) хүлээн авна.

3.3. Нийгмийн ажилтан нь үйлчилгээнд хамрагдах хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэний бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 15 хоногт багтаан хэрэгцээ, шаардлагын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулна.

3.4. Нийгмийн ажилтан нь хэрэгцээ, шаардлагын үнэлгээг хийхдээ дараахь нөхцөл байдлыг харгалзан үзнэ

3.4.1. Баримт бичгийн бүрдэл;

3.4.2. Хүсэлт гаргагчийн эрүүл мэндийн нөхцөл байдлын судалгаа (ЭХМТК-ийн шийдвэр);

3.4.3. Бие даан амьдрахад учирч буй хүндрэл бэрхшээлийн судалгаа;

3.4.4. Хүсэлт гаргагчийг бие даан амьдрахад ямар төрлийн дэмжлэг шаардлагатай байгаа талаарх судалгаа;

3.4.5. Хүсэлт гаргагчийн гэр бүл, оршин суугаа орчин нөхцөлийн судалгаа;

3.5. Нийгмийн ажилтан нь хэрэгцээ, шаардлагын үнэлгээг хийхдээ 3.4.1-3.4.5 хүртэл заалтын хүрээнд ярилцлага хийж, дүгнэлт гаргана.

3.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний сонирхол, сонголтыг хэрэгцээ, шаардлагыг үнэлгээг хийхдээ харгалзан үзнэ. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн нь үнэлгээний бүх шатанд идэвхтэй оролцох үүрэгтэй.

3.7. Хэрэгцээ, шаардлагын үнэлгээний хуудаст нийгмийн ажилтан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн гарын үсэг зуран баталгаажуулна.

3.8. Нийгмийн ажилтан нь хэрэгцээ, шаардлагын үнэлгээ, дүгнэлтийг ажлын 5 хоногт багтаан аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллагад хүргүүлнэ.

3.9. Энэ журмын 3.5-д заасан үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн аймаг дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний байгууллага нь хөтөч нохой эсвэл бусад төрлийн туслагч нохойны үйлчилгээнд хамруулах саналыг хөтөч нохой сургалтын байгууллагад хүргүүлнэ.

3.10. Нохой эзэмших хүсэлт гаргасан иргэнийг, хүсэлт гаргасан огнооны дагуу бүртгэнэ.

3.11. Хөтөч нохойн сургалтын байгууллага нь хүсэлт гаргасан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй гэрээ байгуулан сургалтыг эхлүүлнэ. Гэрээнд тал тус бүрийн гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагын талаар тодорхой тусгана.

3.12. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар болон нохой сургалтын байгууллага нь хөтөч нохой болон бусад төрлийн нохойг эзэмшигчийн бүртгэл хөтөлж хувийн хэрэг үүсгэнэ. Тайлан, мэдээг ХХҮЕГ цахим болон цаасан хэлбэрээр мэдээллийн санд төвлөрүүлж, улсын хэмжээний мэдээлэл бүрдүүлж, архивт хадгална.

### **Дөрөв. Хөтөч нохойг бэлтгэх, сургах, эзэмшихэд шаардагдах зардал, санхүүжилт**

4.1. Хөтөч нохойг бэлтгэх, сургах, эзэмшихэд шаардагдах зардал гэдэгт нохой үржүүлэг, нохой сургалт, хамтран болон давтан сургалтад шаардлагатай эд зүйлсийн олголт, нохойн хоол, тэжээл, урьдчилан сэргийлэх тарилгатай холбоотой зардлын хөнгөлөлт зэрэг багтана.

4.2. Хөтөч нохойг тусгайлан сургаж бэлтгэх ба дотоодод сургаж бэлтгэсэн хөтөч нохойны үнийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 32.7-д заасны дагуу олгоно.

4.3. Хөтөч нохойн үржүүлэг, урьдчилан сэргийлэх тарилгатай холбоотой зардлын хөнгөлөлт зэргийг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал эмнэлэг үржлийн газар зохих сан, тухайн жилийн үйл ажиллагааны зардалд тусгах замаар зардлыг тодорхой хэсгийг шийдвэрлэж болно.

4.4. Хөтөч нохой нохойн хоол, тэжээлболон нохойг ялгах цээживч хэрэгсэл, нохой сургалт, хамтран болон давтан сургалтад шаардлагатай зарим зардлыг Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн төсөвт тусгах замаар шийдвэрлэж болно.

#### **Тав. Хөтөч нохойг хэрэглэхтэй холбоотой үүрэг, хариуцлага**

5.1. Хөтөч нохой эзэмшигч нь нохойг зориулалтын дагуу ашиглана.

5.2. Нохой эзэмшигч нь эрүүл аюулгүй аюулгүй хүнсээр хангах үүрэгтэй.

5.3. Сургалтын байгууллагаас тогтоосон хугацаанд эрүүл мэндийн үзлэг вакцинд хамруулна.

5.4. Сургалтын байгууллагаас тогтоосон хугацаанд давтан сургалтанд хамруулна.

5.5. Эзэмшигч нь хөтөч нохойг олон нийтийн газарт дагуулан явахдаа зориулалтын хувцас хэрэгслийн зайлшгүй өмсгөж зүүсэн байна.

5.6. Хөтөч нохойн эзэмшигч болох хөгжлийн бэрхшээлтэй хүн энэ журмын 5.1-5.5-д заасан үүргийг биелүүлүүлээгүй тохиолдолд, Хөтөч нохойг бэртээж гэмтээсэн, амь насыг нь хохироосон этгээд зөрчил гаргасан гэж үзэн зохих хууль журмын дагуу торгууль, хариуцлага оногдуулна.

#### **Зургаа. Бусад зүйл**

6.1. Энэхүү журмын заасанчлан сургасан хөтөч болон бусад туслагч нохойг нохойн улаан хүрэн өнгийн цээживч хантааз, шар өнгийн пайз, оосор зүүж ялгана.

6.2. Хөтөч нохойг хэрэглэх олон нийтэд сурталчилан таниулах асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ХХААХҮЯ, ЦЕГ зохион байгуулах бөгөөд ХБИ -ийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдан ТББ-аар гэрээлэн гүйцэтгүүлж болно.

6.3. Энэ журмын хэрэгжилтэд Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.